

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2023/164/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2023 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитор М.Нурболат

Утас: 9902-7275, Цахим хаяг: lightanddelightaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|---|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ..... | 2 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ..... | 4 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 10 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 12 |
| 4.1 Ерөнхий зүйл..... | 12 |
| 4.2 Материаллаг байдал | 12 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 13 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 13 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 13 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 13 |
| 4.5.1 Завсрын аудитын талаар..... | 13 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 14 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 14 |
| 5.1 Төлбөрийн акт | 14 |
| 5.2 Албан шаардлага..... | 14 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 16 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.02.24 № 272
танай _____-ны № _____-т

Г МАТАД СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Б.ЭНХТУЯА ТАНАА Т

Г Хязгаарлалттай дүгнэлт Т

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бараа материалын тооллогыг хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ" 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2. "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Аудитаар тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудал байна. Үүнд: Бараа материалын дансанд бүртгэлтэй 64.8 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлд тооллого хийгээгүй, баталгаажуулж дүнг санхүүгийн тайланд тусгасан байна.

011020386

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|-----------------|-----------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 142,322,204.90 | 106,371,759.32 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 13,821,444.19 | 40,005,417.68 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 13,821,444.19 | 40,005,417.68 |
| 3121 | Төгрөг | 13,821,444.19 | 40,005,417.68 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 13,821,444.19 | 40,005,417.68 |
| 33 | АВЛАГА | 76,700,520.00 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 76,700,520.00 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 51,800,240.71 | 66,366,341.64 |
| 351 | Түүхий эд материал | 21,560,500.00 | 43,272,260.35 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 280,500.00 | - |
| 35130 | Эм боох материал | 21,280,000.00 | 43,272,260.35 |
| 354 | Хангамжийн материал | 28,687,740.71 | 21,542,081.29 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,343,100.00 | 2,150,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 8,226,500.00 | 4,733,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 5,083,716.22 | 1,370,176.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,355,816.20 | 1,610,297.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 11,678,608.29 | 11,678,608.29 |
| 35600 | Мал амьтад | 1,552,000.00 | 1,552,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 521,744,976.67 | 545,376,829.53 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 521,744,976.67 | 545,376,829.53 |
| 392 | Биет хөрөнгө | 503,447,776.67 | 527,811,517.57 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 334,618,065.37 | 334,618,065.37 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (28,944,381.13) | (36,000,079.45) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 162,256,325.00 | 162,256,325.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (53,294,387.48) | (79,739,774.96) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 116,659,131.86 | 149,247,137.14 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (55,557,109.26) | (81,748,019.35) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 29,591,104.00 | 33,723,104.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (16,295,471.99) | (18,694,071.59) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 156,000.00 | 156,000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (141,499.70) | (147,299.90) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 30,057,802.00 | 81,644,600.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (15,657,802.00) | (17,504,468.69) |
| 393 | Биет бус хөрөнгө | 18,297,200.00 | 17,565,311.96 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 18,297,200.00 | 18,297,200.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | - | (731,888.04) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 664,067,181.57 | 651,748,588.85 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 664,067,181.57 | 651,748,588.85 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 664,067,181.57 | 651,748,588.85 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 374,743,288.99 | 374,743,288.99 |
| 51101 | Өмч:- төрийн | 374,743,288.99 | 374,743,288.99 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 281,966,179.48 | 269,647,586.76 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 171,639,294.16 | 281,966,179.48 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 110,326,885.32 | (12,318,592.72) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 7,357,713.10 | 7,357,713.10 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 664,067,181.57 | 651,748,588.85 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|---------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 768,101,666.56 | 614,050,210.10 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 177,636,256.56 | 93,637,020.10 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 177,636,256.56 | 93,637,020.10 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 177,636,256.56 | 93,637,020.10 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 344,540.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 4,110,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 177,291,716.56 | 89,527,020.10 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 590,465,410.00 | 520,268,190.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 400,983,900.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 400,983,900.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 159,494,480.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 159,494,480.00 | - |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт орлого | | 145,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 13,041,600.00 | 28,288,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 13,041,600.00 | 28,288,600.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 16,945,430.00 | 491,979,590.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 16,945,430.00 | 491,979,590.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 657,774,781.24 | 626,368,802.82 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 657,774,781.24 | 626,368,802.82 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 622,388,356.63 | 606,868,802.82 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 331,691,847.43 | 324,657,788.15 |
| 210101 | Үндсэн цалин | 180,400,571.81 | 225,080,566.36 |
| 210102 | Нэмэгдэл | 94,465,722.88 | 58,396,499.62 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,917,970.95 | 665,814.00 |
| 210104 | Урамшуулал | 53,907,581.79 | 40,514,908.17 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 44,937,998.66 | 46,240,957.56 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,135,364.66 | 32,757,382.80 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,450,710.00 | 4,313,566.74 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,760,448.00 | 3,059,628.69 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 690,148.00 | 659,085.55 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,901,328.00 | 5,451,293.78 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5,748,775.39 | 3,822,500.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,558,775.39 | 3,372,500.00 |
| 210302 | Түлш, халаалт | 2,950,000.00 | - |
| 210303 | Цэвэр, бохир ус | 240,000.00 | 450,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 16,986,527.48 | 56,237,385.34 |
| 210401 | Бичиг хэрэг | 937,640.00 | 7,184,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,869,499.48 | 28,734,085.22 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 943,000.00 | 902,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,399,900.00 | 200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 836,488.00 | 19,216,600.12 |
| 2105 | Нормативт зардал | 162,866,308.07 | 101,247,150.35 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 152,980,090.00 | 91,640,471.15 |
| 210502 | Хоол, хүнс | 7,486,218.07 | 9,606,679.20 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,400,000.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,708,200.00 | 339,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,385,000.00 | 315,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,323,200.00 | 24,800.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,350,000.00 | 3,684,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,350,000.00 | 3,684,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,285,450.00 | 4,132,371.00 |

Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|--------|--|-----------------------|------------------------|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 2,180,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 270,000.00 | 270,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 799,450.00 | 200,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 107,071.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 55,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,300,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 19,800.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 150,000.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 52,813,249.60 | 66,506,850.42 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,059,725.00 | 1,831,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 50,753,524.60 | 64,674,950.42 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 35,386,424.61 | 19,500,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 32,746,000.00 | 19,500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 32,746,000.00 | 19,500,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 2,640,424.61 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,640,424.61 | - |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>110,326,885.32</u> | <u>(12,318,592.72)</u> |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>110,326,885.32</u> | <u>(12,318,592.72)</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>590,809,950.00</u> | <u>601,223,710.00</u> |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 4,110,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 4,110,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 4,110,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 4,110,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 590,809,950.00 | 597,113,710.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 400,983,900.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 400,983,900.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 159,839,020.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 159,494,480.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 344,540.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 13,041,600.00 | 28,288,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 13,041,600.00 | 28,288,600.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 16,945,430.00 | 568,825,110.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 16,945,430.00 | 568,825,110.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>571,826,925.81</u> | <u>575,039,736.51</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 571,826,925.81 | 575,039,736.51 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 536,440,501.20 | 555,539,736.51 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 331,691,847.43 | 324,657,788.15 |
| 210101 | Үндсэн цалин | 180,400,571.81 | 225,080,566.36 |
| 210102 | Нэмэгдэл | 94,465,722.88 | 58,396,499.62 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,917,970.95 | 665,814.00 |
| 210104 | Урамшуулал | 53,907,581.79 | 40,514,908.17 |

Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|--------|--|----------------|---------------|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 44,937,998.66 | 46,240,957.56 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,135,364.66 | 32,757,382.80 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,450,710.00 | 4,313,566.74 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,760,448.00 | 3,059,628.69 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 690,148.00 | 659,085.55 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,901,328.00 | 5,451,293.78 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 7,892,875.39 | 23,288,600.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,558,775.39 | 3,372,500.00 |
| 210302 | Түлш, халаалт | 5,094,100.00 | 19,466,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 240,000.00 | 450,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 20,176,871.72 | 23,725,745.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,196,450.00 | 2,057,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,629,821.72 | 16,004,445.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 943,000.00 | 902,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,783,000.00 | 478,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,624,600.00 | 4,283,500.00 |
| 2105 | Нормативт зардал | 116,759,320.00 | 90,659,194.80 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 107,976,570.00 | 80,008,034.80 |
| 210502 | Хоол, хүнс | 6,382,750.00 | 9,861,160.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,400,000.00 | 790,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,229,720.00 | 31,144,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,721,420.00 | 23,612,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,508,300.00 | 7,532,100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,350,000.00 | 3,684,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,350,000.00 | 3,684,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,402,258.00 | 6,682,371.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 4,730,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 270,000.00 | 270,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 799,450.00 | 200,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 116,808.00 | 107,071.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 55,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,300,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 19,800.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 150,000.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,999,610.00 | 5,456,980.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,999,610.00 | 5,456,980.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 35,386,424.61 | 19,500,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 32,746,000.00 | 19,500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 32,746,000.00 | 19,500,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 2,640,424.61 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,640,424.61 | - |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 18,983,024.19 | 26,183,973.49 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 5,161,580.00 | - |

Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|--------|---|----------------|---------------|
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 5,161,580.00 | - |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 5,161,580.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 5,161,580.00 | - |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (5,161,580.00) | - |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 13,821,444.19 | 26,183,973.49 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 13,821,444.19 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 13,821,444.19 | 40,005,417.68 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| C01 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 374,743,288.99 | 7,357,713.10 | 171,639,294.16 | 553,740,296.25 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 374,743,288.99 | 7,357,713.10 | 171,639,294.16 | 553,740,296.25 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 110,326,885.32 | 110,326,885.32 |
| C08 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 374,743,288.99 | 7,357,713.10 | 281,966,179.48 | 664,067,181.57 |
| D01 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 374,743,288.99 | 7,357,713.10 | 281,966,179.48 | 664,067,181.57 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 374,743,288.99 | 7,357,713.10 | 281,966,179.48 | 664,067,181.57 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (12,318,592.72) | (12,318,592.72) |
| D09 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 374,743,288.99 | 7,357,713.10 | 269,647,586.76 | 651,748,588.85 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|--|-----------------------|----------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 628,738,800.00 | 511,641,463.06 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 628,738,800.00 | 511,641,463.06 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 628,738,800.00 | 511,641,463.06 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 408,245,700.00 | 318,062,602.04 |
| 210101 | Үндсэн цалин | 307,663,800.00 | 225,080,566.36 |
| 210102 | Нэмэгдэл | 46,855,400.00 | 58,396,499.62 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,310,600.00 | 665,814.00 |
| 210104 | Урамшуулал | 48,415,900.00 | 33,919,722.06 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 52,698,100.00 | 46,196,328.67 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,404,600.00 | 32,757,382.80 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,073,400.00 | 4,268,937.85 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,258,700.00 | 3,059,628.69 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 814,700.00 | 659,085.55 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,146,700.00 | 5,451,293.78 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 23,288,600.00 | 22,172,141.55 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,238,600.00 | 2,256,041.55 |
| 210302 | Түлш, халаалт | 18,600,000.00 | 19,466,100.00 |

Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|--------|--|-----------------------|-----------------------|
| 210303 | Цэвэр, бохир ус | 450,000.00 | 450,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 28,260,700.00 | 23,725,745.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,600,000.00 | 2,057,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,165,100.00 | 16,004,445.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,215,600.00 | 902,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,300,000.00 | 478,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,980,000.00 | 4,283,500.00 |
| 2105 | Нормативт зардал | 59,082,100.00 | 54,541,994.80 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 43,892,100.00 | 43,890,834.80 |
| 210502 | Хоол, хүнс | 12,390,000.00 | 9,861,160.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,800,000.00 | 790,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 33,502,000.00 | 31,119,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 24,582,500.00 | 23,612,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,919,500.00 | 7,507,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,800,000.00 | 3,684,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,800,000.00 | 3,684,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,804,800.00 | 6,682,371.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,750,000.00 | 4,730,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 270,000.00 | 270,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 200,000.00 | 200,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 165,000.00 | 107,071.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 100,000.00 | 55,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,300,000.00 | 1,300,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 19,800.00 | 19,800.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,056,800.00 | 5,456,980.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,056,800.00 | 5,456,980.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 628,738,800.00 | 537,825,436.55 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 28,288,600.00 | 27,147,341.55 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 28,288,600.00 | 27,147,341.55 |
| 122 | ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ | 600,450,200.00 | 510,678,095.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 600,450,200.00 | 510,678,095.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 13,821,444.19 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 40,005,417.68 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|------------|--|----------------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 62,257,015.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 62,257,015.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 42,757,015.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 6,639,815.00 |
| 210104 | Урамшуулал | 6,639,815.00 |
| 2105 | Нормативт зардал | 36,117,200.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 36,117,200.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 19,500,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 19,500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 19,500,000.00 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн төв нь эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг ард иргэдэд жигд хүртээмжтэй хүргэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, хүн амын амьдралын хэв маягийг өөрчлөх, зөв дадал зуршилд сургахад чиглэгдэнэ.

Эрхэм зорилго: Хөдөөгийн хүн амд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй чанартай хүргэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ард иргэдэд хүргэн үйлчилж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12.3 сая төгрөгөөр буюу 1.9 хувиар буурсан байна.

Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|------------------|------------------|-------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 13,821.4 | 40,005.4 | 26,184.0 |
| Авлага | 76,700.5 | - | (76,700.5) |
| Бараа материал | 51,800.2 | 66,366.3 | 14,566.1 |
| Үндсэн хөрөнгө | 521,745.0 | 545,376.8 | 23,631.9 |
| Нийт хөрөнгө | 664,067.2 | 651,748.6 | (12,318.6) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 664,067.2 | 651,748.6 | (12,318.6) |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 664,067.2 | 651,748.6 | (12,318.6) |

Авлага 76.7 сая төгрөгөөр буурсан нь 2021 онд үүссэн авлага бүрэн төлөгдсөнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 66.4 сая төгрөг болж, 14.6 сая төгрөгөөр өссөн байна Энэ нь эм боох материал 21.9 сая төгрөгөөр нэмэгдсэн болон хангамжийн материал 7.1 сая төгрөгөөр буурсан нь гол нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө данс 23.6 сая төгрөгөөр өссөн нь машин тоног төхөөрөмж (компьютер) данс 32.6 сая төгрөгөөр, бусад үндсэн хөрөнгө 51.5 сая төгрөгөөр өссөн бол тайлант хугацаанд 64.6 сая төгрөгийн элэгдэл тооцсонтой холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо данс 650.1 сая төгрөг болж 13.8 сая төгрөгөөр буурсан нь тайланд хугацааны алдагдалтай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 593.7 сая төгрөгөөр, нийт зарлагыг 593.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 593.7 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвч өөрчлөлт ороогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 510.6 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 491.9 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 76.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 484.4 сая төгрөг буюу 80.7 хувьтай байна.

Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| <i>/Мянган төгрөгөөр/</i> | | | | | |
|---------------------------|---------------------------------------|------------|-----------|-----------|---------|
| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
| 1 | Нэг иргэнд тооцох нормативаар тооцсон | 331,407.7 | 234,244.6 | 97,163.1 | 70.7 |
| 2 | Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 237,522.6 | 219,438.4 | 18,084.2 | 92.4 |
| 3 | Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан | 31,519.9 | 30,811.1 | 708.8 | 97.8 |
| | Нийт | 600,450.2 | 484,494.1 | 115,956.1 | 80.7 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас 76.8 сая төгрөгийн, дээд шатны төсвийн захирагчаас 4.1 сая төгрөг нийт 80.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Нэмэлт дансанд орж ирсэн санхүүжилтээс 62.2 сая төгрөгийг зарцуулж үлдэгдэл 14.5 сая төгрөгийг үндсэн дансанд төвлөрүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Лайт энд Дилайт Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Нурболат, аудитор Ц.Төмөрсүх, хяналтыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудит менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 657.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор санхүүгийн сахилга батыг мөрдөж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах бодлогыг баримтлан ажилласан байна.

Тухайн байгууллагын батлагдсан орон тоон дээр дэд дарга, орлогчийн албан тушаалын ажилтан байхгүй байгаа бөгөөд авто тээврийн хэрэгсэл нь эмнэлгийн тусламж үйлчилгээ буюу төрийн хэмнэлтийн хуулийн 6 дугаар зүйлд заасан авто тээврийн хэрэгсэл ашиглах хэрэгцээ, шаардлагатай байгууллага байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус байгууллага нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 14 мэдээ хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 566.6 сая төгрөгийн орлогын гүйлгээг мэдүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаад албан шаардлага хүргүүлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 1 төлбөрийн акт, 3 албан шаардлага хүргүүлсэн бөгөөд хэрэгжилт 12 хувь байна.

Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|------------------|----------|-----------------|------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 3 | 483,999.2 | 1 | 59,642.3 | 12% |
| Акт | 1 | 472.3 | 1 | 472.3 | 100% |
| Нийт дүн | 4 | 484,471.5 | 2 | 60,114.6 | 12% |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдах авах гэрээ, тайланг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуультай нийцэж байх эсэхийг үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13.6 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд: Гурван сая төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгийг орлогод авахдаа хөрөнгийн өртөг болон ашиглалтын хугацааг сольж алдаатай орлогод авсан, 9.0 сая төгрөгийн бараа материалын ажил гүйлгээг ангилал буруу дансанд орлогод авсан, зарлага гаргасан, 1.5 сая төгрөгийн авлагыг зардалд бүртгэснийг бүртгэл, тайланд залруулан тусгуулсан болно.

Аудитаар нийт 109.3 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 2.2 сая төгрөг төлбөрийн 2 төлбөрийн акт, 107.1 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

1. Матад сумын Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогчид эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүй 254,166.10 төгрөгийн нэмэгдэл хөлс илүү олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 3-д “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно гэж заасныг тус тус зөрчсөн байна.
2. Тус эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны Б/31 тоот тушаалаар коронавирусийн халдвар /ковид-19/-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээнд ажилласан албан хаагчдыг урамшуулах зорилгоор 22 ажилтанд нийт 19.5 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгосон. Энэ нь хуульд тусгайлан заасан орлого биш бөгөөд ХХОАТ суутгаагүй байна.

5.2 Албан шаардлага

1. Бараа материалын дансанд бүртгэлтэй 64.8 сая төгрөгийн хөрөнгөд тооллого хийгээгүй, баталгаажгаагүй дүнг санхүүгийн тайланд тусгаж тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Матад сумын Эрүүл мэндийн төв нь 23.8 сая төгрөгийн худалдан авалтын нэмэгдсэн өртгийн албан татварын цахим төлбөрийн баримт гаргуулан аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, сангийн сайдын 2017 оны 347 тушаалаар батлагдсан өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм ...” гэж заасныг зөрчсөн, хэрэгжүүлж ажиллаагүй байна.
3. Матад сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны Б/43 тоот тушаалаар Засгийн газрын 5 дугаар тогтоолын Төрийн албан хаагчид шагнал олгох журмын 3.3-ыг үндэслэн 19 ажилтанд 18.8 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон. Энэ нь тус журамд зааснаар мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болох бөгөөд байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байх бөгөөд нийт ажилтнуудад хавтгайруулан олгохгүй байхаар байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--|------------|-----------------|-----------------------------------|----------|--------------------------|-----------------|------------|-----------------|--------------|----------|----------|----------|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант хугацаанд орлогод авсан үндсэн хөрөнгийн өртөг болон ашиглалтын хугацааг сольж алдаатай орлогод авсан. | 1 | 3,000.0 | | | 1 | 3,000.0 | 1 | 3,000.0 | | | | |
| Бараа материалын ажил гүйлгээг буруу дансанд орлогод авсан, зарлага гаргасан. Тухайлбал галлагаанд хэрэглэх нүүрсийг аж ахуйн материал дансанд бүртгэсэн. | 1 | 9,100.0 | | | 1 | 9,100.0 | 1 | 9,100.0 | | | | |
| Дорнод аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны улсын ахлах байцаагчийн 2022.12.07-ны өдрийн 25-02-112 дугаар бүхий актаар 5 насны 14 толгой 1,552,000 төгрөгийн өртөгтэй малыг төлүүлэх тухай төлбөрийн акт тогтоогдсон. Үүнийг ЭМТ-ийн эрхлэгчээр төлүүлэх тухай акт гарсан тул данснаас хассан байна. | 1 | 1,552.0 | | | 1 | 1,552.0 | 1 | 1,552.0 | | | | - |
| Дүн | 3 | 13,652.0 | - | - | 3 | 13,652.0 | 3 | 13,652.0 | - | - | - | - |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Үүнээс | | | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|--|-------------|----------|---------------|---------|-----------------|----------|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | | | | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Жилийн эцсээр зөвхөн үндсэн хөрөнгийг тоолсон бөгөөд бараа материалын үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй. | 1 | 64,814.3 | | | 1 | 64,814.3 | | | | | | |
| 2022 онд харилцагчдаас худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн төлбөрт төлбөрийн цахим баримт дутуу шивүүлсэн. | 1 | 23,861.9 | | | 1 | 23,861.9 | | | | | | |
| ЭМТ-ийн даргын 2021.12.21-ний өдрийн Б/31 тоот тушаалаар коронавирусийн халдвар /ковид-19/-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээнд ажилласан албан хаагчдыг урамшуулах зорилгоор нэг удаагийн тэтгэмж олгосон. Энэ нь хуульд тусгайлан заасан орлого биш бөгөөд ХХОАТ суутгаагүй байна. | 1 | 1,950.0 | 1 | 1,950.0 | | | | | | | | |

Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | | | | | | | | | | |
|--|----------|------------------|----------|----------------|----------|------------------|----------|----------|----------|----------|----------|----------|
| Тус ЭМТ-ийн даргын 2022.12.26-ны өдрийн Б/42 тоот тушаалаар 4-р улирлын урамшуулал, мөн өдрийн Б/43 тоот тушаалаар 19 ажилтанд 18,850,000 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон. Засгийн газрын 5 дугаар тогтоолын Төрийн албан хаагчид шагнал олгох журмын 3.3-ыг үндэслэсэн бөгөөд бүх ажилчдыг урамшуулсан. | 1 | 18,850.0 | | | 1 | 18,850.0 | | | | | | |
| 2022 оны 12-р сард нягтлан бодогчид 225,925.38 төгрөгийн нэмэгдэл цалин илүү олгосон. | 1 | 254.2 | 1 | 254.2 | | | | | | | | |
| Дүн | 5 | 109,730.4 | 2 | 2,204.2 | 3 | 107,526.2 | - | - | - | - | - | - |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | /мянган төгрөгөөр/ | | | | | |
|---|-------------|------------------|--------------------|----------|-----------------|------------------|----------|----------|
| | | | Үүнээс | | | Зөвлөмж | | |
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Тоо | Дүн |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 2022 онд 14 мэдээг хугацаа хоцроосон, шилэн дансны мэдээллийг байршуулахдаа цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий санхүүжилтийн орлогын дүнг мэдүүлээгүй. | 1 | 566,671.7 | | | 1 | 566,671.7 | | |
| Дүн | 1 | 566,671.7 | 0 | - | 1 | 566,671.7 | 0 | - |